

ӨНГӨ ИЛЭРХИЙЛСЭН ҮГИЙН ҮНДЭСНИЙ СОЁЛЫН УТГЫГ ОРЧУУЛАХ НЬ

Г.Элдэв-Очир⁴⁵

Abstract: *There are abundant color words which have a air of emotion and cultural meaning both in Mongolian and Chinese. The difference between the cultural meaning of those color words in these two languages is caused by different social and cultrual backgrounds of these two nations and shows the cultral psychology from one perspective. The differences between the two nations in geography, environment, national history, morality and beliefs, customs and living habits, values, ways of thinking, all cause the fact that for the same color words, the national cultural semantics are different. However, both of Mongolia and China are oriental countries and have been influencing each other in many aspects and it is nothing surprising that we find color words in these two languages share the same national cultural connotation. By the contrast of those two languages, we are enabled to find the similarities and dissimilarities of the national cultural connotation of color words in these two languages. And it is very meaningful to apply the results of the research to the field of mutual translation. Translation is the transformation of the information one language carries to another language. In transforming, the key is national cultural lexicon. For a perfect transformation, one is required to understand the national cultural connotation of one language and which means an understanding of the cultural meaning the language carries.*

Түлхүүр үг: *өнгө илэрхийлсэн үг, үндэсний соёлын утга, орчуулгазүй, орчуулгын арга*

Орчуулгазүй бол аж-хэл шинжлэлийн (applied linguistics) нэгэн чухал салбар судлал бөгөөд хэлний бусад салбар судлалын адилаар эртнээс эдүгээ хүртэл олон орны эрдэмтдийн хамтын бүтээлийн үр шим, ололт амжилт тул эдүгээ хүртэл түүхэн урт удаан хугацааны турш хөгжсөөр иржээ.

Орчуулга гэдэг нь угтаа тухайн хэлээр илэрхийлж буй мэдээллийг өөр хэлээр илэрхийлэх үйлдэл билээ. Түүнчлэн орчуулга бол өөр өөр хэлээр хэлэлцэгч хүмүүсийн хооронд өрнөж буй хэлэхүйн үйл явц төдийгүй, хоёр хэлний хооронд мэдээлэл дамжуулах нийгмийн харилцааны зорилгыг хангадаг. Мөн орчуулга нь нэг хэлнээс нөгөө хэл рүү буулгахаас гадна, тухайн хэл дотроо ч хийгддэг.

Тухайн хэлээр байгаа эхийг нөгөө хэл рүү орчуулахад орчуулгын арга, ур чадвар шаарддаг нь бүтээлч шинжтэй ажээ. Энэ үүднээс авч үзвэл, орчуулга бол нэгэн төрлийн шинэ бүтээл болдог. Гэвч орчуулга болон жинхэнэ бүтээл хоёр хоорондоо ялгаатай нь ойлгомжтой юм. Орчуулгын гол үүрэг нь тухайн хэлээр байгаа мэдээллийг нөгөө хэлэнд бодитойгоор, үнэн зөв, чадамгай буулгах явдал билээ. Өөрөөр хэлбэл, мэдээллийн агуулгыг өөрчилж, нэмж хасч болохгүй. Иймээс орчуулга нь бүтээлч чанарыг агуулдаг бөгөөд энэ бол орчуулгын онцлог хийгээд бэрхшээлтэй тал болно.

⁴⁵ Доктор /Ph.D/, МУИС, ШУС, ХУС-ын Ази судлалын тэнхим

Орчуулга нь түүх, соёл, угсаатны зүй, утга зохиол, сэтгэл судлал зэрэг олон сав ухаантай нягт холбоотой байдаг. Эдгээр шинжлэх ухааны судалгааны үр дүн, мэдлэг мэдээлэл зэрэг нь орчуулгазүйд их нөлөө үзүүлдэг. Гэвч орчуулга нь утгаа хэлийг хэрэглэх үйл явц бөгөөд ихэвчлэн хэл шинжлэлийн талаас судлах шаардлагатай байдаг.

Түүх, соёлын мэдлэг нь хэлний орчинг шинжлэх, хэл ярианы мэдээллийн агуулгыг тогтооход чухал ач холбогдолтой билээ. Учир нь, тухайн үндэстний хэл нь тэрхүү үндэстнийхээ түүх, соёл, сэтгэлгээг тусгасан байдаг. Иймд орчуулга хийхэд хүндрэл учруулдаг зүйлүүдийн нэг нь цаад хэлний үндэсний соёлын утга бүхий үг хэллэгийг зөв оновчтой оноож буулгах явдал юм. Энэхүү үндэсний соёлын утгыг зөв оноон орчуулахын тулд тэр үндэстнийхээ түүх, соёл, сэтгэлгээг сайтар ойлгож, мэддэг байх шаардлага гарна.

Үндэсний соёлын утга гэдэг нь тухайн хэлээр хэлэлцэгч үндэстний түүх, соёл, зан заншил зэргийг тусгасан, үндэсний соёлын онцлог бүхий утгыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, үгийн сангийн утга дээр үндэсний соёлын онцлог, өнгө аяс нэмэгдсэнээр үндэсний соёлоос нь салгавал ойлгоход бэрх утга бий болдог. Үндэсний соёлын утга нь ихэвчлэн шилжсэн утга байдаг боловч бусад ердийн шилжсэн утга, олдмол утга, салаа утгаас ялгаатай нь гагцхүү үндэсний соёлтой заавал холбоотой, үндэсний соёлын ухагдахуунуудыг агуулж байдаг оршино. Аль ч хэлэнд үндэсний соёлын утга бүхий үг хэллэг байдаг бөгөөд энэ талын судлал нь гадаад хэл заах арга, орчуулга, соёл дамнасан харилцаа зэрэгт туйлын ач холбогдолтой билээ. Үндэсний соёлын утга нь үндэсний онцлог үг хэллэгээс гадна, хүний нэр, газар усны нэр, амьтан ургамлын нэр, өнгө илэрхийлсэн үг болон тогтвортой хэллэг зэрэгт их байдаг байна. (Ван Дөчүнь, 2002:167)

Дээрхээс үзэхэд, тухайн хэлээр илэрхийлж буй мэдээллийг нөгөө хэлээр орчуулан буулгах нь амаргүй бөгөөд ялангуяа үндэсний соёлын утгыг орчуулах нь туйлын ярвигтай болох нь харагдаж байна. Бид энэхүү өгүүлэлдээ монгол, хятад хэлний өнгө илэрхийлсэн үгийн үндэсний соёлын утгын орчуулгаар жишээ болгон дээрх санааг тайлбарлахыг хичээсэн юм.

Өнгө илэрхийлсэн үг бол аль ч хэлэнд байдаг бөгөөд хэлэхүйд өнгөнөөс гадна тухайн үндэстнийхээ түүх, соёл, сэтгэлгээг тусгасан олон утга илэрхийлэх чадамжтай байдаг. Иймээс өнгө илэрхийлсэн үгээр илрэх үндэсний соёлын утгуудыг нарийн оноож орчуулах явдал чухал юм. Судалгаанаас үзэхэд монгол, хятад хэлний өнгө илэрхийлсэн үгийн үндэсний соёлын утгыг 4 аргаар орчуулж болохоор байна. Үүнд:

1. Шууд буюу үгчилж орчуулах арга.

Энэ нь орчуулах эхийн агуулга, хэлбэрийг хадгалж тэр хэвээр нь шууд орчуулахыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, үндэсний соёлын утга бүхий үг хэллэгтэй ижил утга, хэлбэртэй үг нөгөө хэлэнд байвал тэр үг хэллэгээр шууд орчуулж болно гэсэн үг юм. Энэ нь хоёр үндэстэн урт удаан түүхийн явцад соёл, зан заншлын хувьд бие биедээ нөлөөлсөн, нэг нь нөгөөгөөсөө авсан гэх мэт олон хүчин зүйлийн үр нөлөө юм. Иймд хоёр хэлэнд ижил утга, хэлбэр бүхий үг,

хэллэг бий болох нөхцөл бүрддэг байна. Монгол, хятад хэлний зарим өнгө илэрхийлсэн үгийн үндэсний соёлын утга ижил байх тохиолдол цөөнгүй гарч байна. Ийм аргаар орчуулахад уншигч, сонсогчид цаад хэлний утга, агуулга, сэтгэлгээг төвөггүй ойлгодог. Жишээлбэл, монгол, хятад хоёр хэлэнд “улаан цэрэг” гэдэг үг хэллэг бий бөгөөд “улаан” өнгө илэрхийлсэн үг нь хоёр хэлэнд ижилхэн “хувьсгал” гэсэн үндэсний соёлын утга агуулж байдаг. Иймд монгол хэлний “улаан цэрэг” гэдэг үгийг хятад хэлэнд шууд “红军” гэж буулгахад болно. Мөн хятад хэлэнд “绿旗宾” гэсэн үг хэллэг бий. Энэ хэллэгийн “绿” буюу “ногоон” өнгө илэрхийлсэн үг нь “хятад үндэстэн” гэсэн үндэсний соёлын утга илэрхийлдэг. Учир нь Манж Чин улсын үед Манж, Монгол, Хятад цэргүүд шар, цагаан, хөх, улаан, ногоон туг барьж жагсдаг, түүгээрээ нэрлэгддэг байжээ. Тэр үед хятад цэргүүд ногоон тугийн дор жагсдаг тул тэднийг “绿旗宾” буюу “ногоон тугийн цэрэг” гэж нэрлэдэг нь түүхийн сурвалж бичигт үлджээ. Иймд эл үгийг Монгол хэлнээ “ногоон тугийн цэрэг” хэмээн шууд буулгахад болохоор байна.

2. Ондoo өнгө илэрхийлсэн үгээр орчуулах арга.

Тухайн хэлний өнгө илэрхийлсэн үгийн үндэсний соёлын утга нөгөө хэлний дүйцэх өнгө илэрхийлэх үгэнд нь ижил үндэсний соёлын утга байхгүй байж болно. Гэвч ондоо өнгө илэрхийлсэн үгэнд нь ижил үндэсний соёлын утга байж болохыг үгүйсгэж болохгүй бөгөөд ийм үед энэ аргаар орчуулж болох юм. Монгол, хятад хэлний хувьд ч мөн адил. Монгол, хятад хоёр үндэстэн хэдийгээр олон зуун жил хөрш зэргэлдээ явж ирсэн ч гэлээ түүх, соёл, зан заншил, сэтгэлгээ хийгээд ертөнцийг үзэх үзэл зэрэг нь ондоо тул энэ нь хэл бичигтээ тусч орчуулагчдад багагүй бэрхшээл учруулдаг билээ. Гэвч уншигч, сонсогчдод ойлгомжтой байлгах үүднээс өнгө илэрхийлсэн үгээр илэрч буй үндэсний соёлын утгыг нарийн ажиглаж, ойролцоо буюу ижил үндэсний соёлын утга бүхий үг, хэллэгээр оноон орчуулах явдал туйлын чухал юм. Энэхүү аргын ач холбогдол нь уншигч, сонсогчид өөрийн хэлний үндэсний соёлын утгаар баримжаа авч өөр үндэстний түүх, соёл, зан заншлыг ухаарч ойлгоход дөхөмтэй байдаг. Энэ арга нь орчуулах эхийн утга, агуулгыг баримталж, хэлбэрийг баримтлалгүй өөрөөр буулгах явдал болно. Тухайлбал, монгол хэлний “бор гэр” гэсэн үг хэллэгт бор өнгө илэрхийлсэн үг “ядуу, тарчиг” гэсэн үндэсний соёлын утга илэрхийлдэг. Хятад хэлэнд энэ үгтэй дүйцэх утгатай “白屋” (цагаан байр) гэсэн үг бий. Энэ үг хэллэгийн “白” буюу цагаан өнгө илэрхийлсэн үг дээрхтэй адил утга илэрхийлж байна. Учир нь цагаан өнгө бол хятад үндэстний хувьд тааруу, дорд өнгө бөгөөд муу муухайг бэлгэддэг. Мөн монгол хэлний цагаан өнгө илэрхийлсэн үг “өндөр дээд, эрх мэдэл” гэсэн үндэсний соёлын утга илэрхийлдэг. Хятад хэлэнд энэ үгтэй дүйцэх утгатай “紫衣” (ягаан хувцас) гэсэн үг бий. Ягаан өнгө бол эртний хятад үндэстний хувьд эрхэм дээд, язгууртан, эрх мэдэл зэргийг бэлгэддэг тул монгол хэлний “цагаан” өнгө илэрхийлсэн үгтэй ижил утга илэрхийлдэг байна.

3. Өнгө илэрхийлээгүй үгээр орчуулах арга.

Нэг хэлэнд буй өнгө илэрхийлсэн үгийн үндэсний соёлын утгыг нөгөө хэлэнд дүйцэх утга бүхий өнгө илэрхийлсэн үг байхгүй тохиолдолд утга ижил өөр

үг, хэллэгээр орчуулж болно. Өөрөөр хэлбэл, орчуулах эхийн утга, агуулгыг голлож уншигч, сонсогчдод ойлгомжтой байлгах үүднээс өнгө илэрхийлээгүй ондоо үг, хэллэгээр оноон орчуулах явдал юм. Энэ бол үндэсний соёлын утгын дүйцэлгүй байх үзэгдэл билээ. Энэхүү үзэгдэл бол нэг үндэстний соёл, зан заншил, сэтгэлгээнд байдаг зүйл нөгөө үндэстний соёл, зан заншил, сэтгэлгээнд дүйцүүлэх зүйл байхгүй байж болох тохиолдол юм. Энэ бол маш түгээмэл байдаг. Ийм тохиолдолд хэлбэрийг голлон ижил өнгө илэрхийлсэн үгээр шууд орчуулбал уншигч, сонсогчдод ойлгомжгүй байхаас гадна төөрөгдөлд оруулдаг. Иймд заавал хэлбэрийг чухалчлалгүй агуулга, утгыг голлон буулгаваас зохилтой билээ. Тухайлбал, монгол хэлний “цагаан идээ” гэдэг үгний “цагаан” өнгө илэрхийлсэн үгэнд “сүү, сүүн бүтээгдэхүүн” гэсэн үндэсний соёлын утга бий. Энэ үгийг хятад хэлэнд шууд “白食” гэж орчуулбал ойлгомжгүй байх тул “奶品” буюу “сүү, сүүн бүтээгдэхүүн” гэж буулгавал сая ойлгомжтой болох юм. Мөн хятад хэлний “白事” гэдэг үг нь “буяны ажил буюу оршуулгын зан үйл” гэсэн үндэсний соёлын утгатай юм. Эл үгийг монгол хэлнээ шууд “цагаан ажил” гэвэл бидэнд ойлгомжгүй байна. Эс бөгөөс өөр утгаар ойлгогдох гэмтэй тул утгыг нь голлон “буяны ажил” гэж буулгавал сая ойлгомжтой болох буй заа. Мөн хятад хэлний “白色收入” гэдэг үгэнд цагаан өнгө илэрхийлсэн үг нь “цэвэр” гэсэн үндэсний соёлын утга илэрхийлэх бөгөөд эл үгийг шууд “цагаан орлого” гэвэл тохиромжгүй тул “цэвэр орлого” гэж буулгавал зохимжтой санагдана.

4. Нэмэлт зүүлт тайлбар хийж орчуулах арга.

Уншигч, сонсогчдод ондоо үндэстний соёл, зан заншил, сэтгэлгээг гүн гүнзгий ойлгуулах үүднээс дүйцэх утга бүхий үг хэллэг байхгүй тохиолдолд энэхүү аргыг хэрэглэж болно. Учир нь хоёр өөр үндэстэнд соёл, зан заншил, сэтгэлгээ хийгээд ертөнцийг үзэх үзлийн хувьд тэс ондоо, ойлгоход бэрх зүйл олон байдаг билээ. Иймд огт ойлгомжгүй үндэсний соёлын утга бүхий үг хэллэгийг орчуулахад ард нь уг ойлголтыг тайлбарласан нэмэлт зүүлт, тайлбар оруулж болно. Тухайлбал, хятад хэлний “黄道吉日” гэдэг үгийг монгол хэлнээ “шар замын өлзийт өдөр” гэж буулгаад ард нь “шар өнгө нь хятадуудын хувьд шүтэж дээдэлдэг өнгө бөгөөд өлзийт сайн өдрөө ийнхүү шар өнгөөр бэлгэддэг байна” гэх мэтээр тайлбарлавал уншигчдад ойлгомжтой байх болов уу гэж санагдана.

Энэ бүгдээс үзэхэд, хэл бол түүх соёл, зан заншил, сэтгэлгээг тусгаж, хадгалж, үеэс үед уламжлан дамжуулж байдаг билээ. Иймд орчуулга зүйд үндэсний соёлын утга, түүний хэрэглээг туйлын их чухалчилж үзвээс зохилтой байна.

Номзүй

1. 常敬宇. 2000. 汉语词汇与文化[M]. 北京: 北京大学出版社
2. 邓炎昌, 刘润清. 1989. 语言与文化[M]. 北京: 外语教学与研究出版社
3. 骆峰. 2004. 汉语色彩词的文化审视[M]. 上海: 上海辞书出版社
4. 王德春. 1990. 汉语国俗词典[Z]. 南京: 河海大学出版社
5. 王德春. 1997. 语言学概论[M]. 上海: 上海外语教育出版社
6. 王德春. 2002. 多角度研究语言[M]. 北京: 清华大学出版社
7. 吴友富. 2001. 国俗语义研究[C]. 上海: 上海外语教育出版社